



**МОНГОЛ ЯПОНЫ ЗАЛУУЧУУДЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ТӨВ**
モンゴル日本青年交流支援センター

**7-дахь удаагийн Япон хэлний уран илтгэлийн
тэмцээний удирдамж**

Монгол Японы Залуучуудын Хамтын Ажиллагааг Дэмжих Төв нь 7 дахь удаагийн Япон хэлний уран илтгэлийн тэмцээний зарыг хүргүүлж байна. Та бүхэн өргөнөөр оролцоно уу.

Тэмцээний зорилго : Япон хэл соёлыг сонирхогчдын тоог нэмэгдүүлэх, япон хэл суралцагчдыг идэвхжүүлэн урамшуулах

Сэдэв : Чөлөөт сэдвээр бичнэ.

Оролцох шалгуур :

- Япон хэлийг ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй ахлах ангийн сурагч
- Их дээд сургуульд Япон хэлийг сонгон хэлбэрээр суралцаж буй 1 ба 2-р курсын оюутан (Япон хэлээр мэргэшин суралцаж буй тохиолдолд оролцох боломжгүй.)
- Япон хэлний сургалтын төвд тус хэлийг сонирхон суралцаж буй суралцагч

※Япон улсад нийт 14-с дээш хоногоор зорчиж байсан бол оролцох боломжгүй

※Япон хэлний багш оролцох боломжгүй.

Шалгаруулалт:

1-р үе шат

Чөлөөт сэдвээр зохион бичлэгийг тусгай цаасан дээр 2.5-3.0 буюу 1000-1200 үсгэнд багтаан бичнэ.

Зохион бичлэгийн тусгай цаас болон оролцогчийн анкетыг тус удирдамжийн хамт хавсаргасан болно.

Анхаарах зүйл : Зохион бичлэгийг Япон хэл дээр цэвэр гаргацтай бичиж тус төв дээр оролцогчийн анкетын хамт биеэр хүргүүлнэ. Зохион бичлэгийг дугтуйнд хийж өөрийн овог нэр, Япон хэл суралцаж буй байгууллагын нэр, төрсөн он сар өдөр, холбоо барих утасны дугаарыг бичнэ. Нэр, хаяг, утасны дугаар тодорхойгүй тохиолдолд шалгаруулалтанд оролцох боломжгүй болохыг анхаарна уу!

Зохион бичлэг хүлээн авах хугацаа : 2020 оны 09 сарын 14-ний өдрөөс 10 сарын 02-ны өдөр хүртэл ажлын өдрүүдийн 09:00-18:00 хооронд

Зохион бичлэгийг хүлээн авах байршил :

Хаяг: Чингэлтэй дүүрэг Төмөрчний гудамж Их Найман Шарга төвийн Голомт банкттай байр 9 давхар 906 тоот (Монгол Японы Залуучуудын Хамтын Ажиллагааг Дэмжих Төвийн байр)
Лавлах утас: 330189, 88070944

Бүргэлийн хураамж: Үнэгүй

Зөвхөн 2-р шатанд орох болзол хангасан хүмүүс рүү утсаар холбоо барьж дараагийн шатны шалгалтын товыг мэдэгдэнэ.

2-р үе шат:

Япон хэл дээр ярилцлагын шалгалт явагдана. /Шалгалтын товыг өмнөх шатны шалгаруулалтанд тэнцсэн оролцогч рүү урьдчилж утсаар мэдэгдэнэ./

Зөвхөн 3-р шатанд орох болзол хангасан оролцогчид утсаар дүн болон дараагийн 3-р шатны сонгон шалгаруулалтын товыг мэдэгдэнэ.

3-р үе шат:

Монгол Японы Залуучуудын Хамтын Ажиллагааг Дэмжих Төвөөс утсаар 2 дахь үе шатад тэнцсэн тухай мэдэгдэл хүлээн авсан оролцогчид 2020 оны 11 сарын 1-ны Ням гаригийн 11 цагт Анкор төвд 3-р шатны буюу сүүлийн сонгон шалгаруулалтанд оролцож илтгэл тавина. Илтгэл нь 1-р шатны зохион бичлэгийн сэдвийн дагуу байх бөгөөд агуулгын хувьд сайжруулсан байж болно.

Илтгэлийн шалгаруулалт нь Япон хэлний чадвар төдийгүй агуулга, бусдад хүргэх чадвар, логик дэс дараалал, асуулт хариултын оновчтой байдал зэрэгт үндэслэгдэнэ.

Илтгэлийн хугацаа 3-4 минут

(Хугацаа хэтэрсэн тохиолдолд үнэлгээнд нөлөөлөхийг анхаарна уу.)

Шагналын сан :

1- р байр 1 – 1,000,000 төгрөг, өргөмжлөл

2- р байр 1 – 500,000 төгрөг, өргөмжлөл

3- р байр 1 – 300,000 төгрөг, өргөмжлөл

3-р шатанд оролцсон илтгэгчдэд оролцогчийн шагнал олгогдоно.

Ивээн тэтгэгч байгууллага:

- Иватани Техник Бизнесийн Мэргэжлийн Сургууль
- Мобиком Корпораци ХХК
- Надешико Трэвел Сервис ХХК

Дэмжигч байгууллага :

- Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яам
 - Голомт банк
-

Нэмэлт тайлбар : Илтгэлийн тэмцээнд дунд сургуульд Япон хэл сурч буй ахлах сургуулийн сурагчид, Япон хэлний сургалтын төвд тус хэлийг сонирхон суралцаж буй залуус оролцох боломжтой. Өөрийн сонирхлоороо суралцаж буй оюутан сурагчид нь их дээд сургуульд Япон хэлээр мэргэшин судалж буй оюутнуудтай харьцуулахад Япон хэлний уран итгэлийн тэмцээнд оролцон өөрийгөө сорих боломж хязгаарлагдмал байдлыг харгалзан үзэж цаашид илүү гүнзгийрүүлэн судлах урам зоригийг өгөх зорилготой болно.

Монгол Японы Залуучуудын Хамтын Ажиллагааг Дэмжих Төв
Асахи Сонины Тэтгэлэгт Хөтөлбөрийн
Албан Ёсны Төлөөлөгчийн Газар Утас: 330189, 88070944